



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/124

Биндэр сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биндэр сумын Засаг даргын тамгын газарт 5000 м² газрыг хог хаягдлын үйлдвэр (2316)-ийн зориулалтыг мал эмнэлгийн үйлчилгээ (1602)-ний болгож өөрчлөн эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгон, газар эзэмших гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2025 оны А/118 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

